



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/53.

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 02, 04 дүгээр хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирус (COVID-19)-ын халдвараас урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах зорилгоор аймаг, сум хооронд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 20.00 цагаас 02 дугаар сарын 15-ны өдрийн 06.00 цаг хүртэл хугацаанд түр хязгаарласугай.

2. XVII жарны "Цагаан сарын баярын үеэр иргэдийг гэртээ зочин урих, айлд зочлохыг, "Шинийн нэг"-ний өглөөний нар харах зорилгоор уул, овоонд гарч бөөгнөрөл үүсгэх, албан байгууллага, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын албан хаагчид болон иргэд, олон нийтийг хамруулсан золголтын арга хэмжээ зохион байгуулахыг тус тус хориглосугай.

3. Монголын Цагаан сарын баярыг аймгийн нутаг дэвсгэрт сум, баг байгууллагын хэмжээнд иргэд, олон нийтээр өргөн тэмдэглэхгүй байж, Коронавируст халдвар (COVID-19)-т цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлыг аймаг, сумын төрийн байгууллага, албан тушаалтнуудыг оролцуулан зохион байгуулахыг бүх шатны Засаг дарга, төрийн байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Голомтот бүс нутгаас ирсэн иргэд гэрийн ажиглалтад байх хугацаанд гэрээс гарахгүй хорио цээрийн дэглэмийг баримталж, мэргэжлийн байгууллагаас өгч байгаа заавар зөвлөмжийг дагаж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөхийг тус иргэдэд уриалсугай.

481210126

5. Сумын Онцгой комиссын үйл ажиллагааг эрчимжүүлэх, баяр амралтын өдрүүдэд ажиллах эргүүлийг томилон үүрэг гүйцэтгүүлэх, иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих хяналтын пост, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, голомтот бүс нутгаас ирж байгаа иргэдийн гэрийн ажиглалтын хяналтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумдын Онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр), Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших), бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

